



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 1/20

Модот

「**Байгууллагын архивын улсын үзлэгийн
бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Улсын үзлэг явуулах тухай” 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн баримтыг зохион байгуулалтын нэгжүүдээс хүлээн авах, бүртгэх ангилж төрөлжүүлэх, архив албан хэрэг хөтлөх журам, стандартыг мөрдүүлэх, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Д.Ариунаа	Сургалтын менежер
Нарийн бичиг: О.Жавзмаа	Архив, бичиг хэргийн ажилтан
Гишүүд: М.Өсөхцэнгэл	Бага ангийн багш
Т.Тунгалагнаран	Бага ангийн багш
Г.Гантуяа	Хими биологийн багш
Б.Гэрэлмаа	Номын санч
Б.Мандах	Дотуур байрны жижүүр

2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн холбогдох заавар, журам баримт бичгийн стандарт хэрэгжилтийг хангуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Ариунаа)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн талаар тайлагнахыг нийт томилогдсон бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ